

“ИНЭЭМСЭГЛЭЛ БИДЭНД УРАМ” ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

Орхон аймаг






2020.01.17

Эрүүл мэндийн яам, Авлигатай тэмцэх газраас хамтарч олон нийтэд чиглэсэн “Инээмсэглэл бидэнд урам” зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, тус хөтөлбөрийн хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн ажилтан, иргэдийн хооронд эерэг зөв хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн газар 7 ажил тусган төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж биелэлт 95 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Үүнд:

1. Эрүүл мэндийн газар дээр уг ажлыг сурталчилан анонсыг байршуулан, 5 ширхэг барнер хийлгүүлэн угтах үйлчилгээнд ашиглан иргэдээс санал, хүсэлт, сэтгэгдлийг хүлээн авч уг аяны хүрээнд 150 иргэнээс талархал, сэтгэлийн үгээ бичсэн байна.



Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Facebook зурагаа “Инээмсэглэл Бидэнд Урам” гэсэн лого дотор профайл зургуудыг хийж давалгаа үүсгэн, иргэдээс сэтгэлийн үгийг нь бичүүлсэн. Мөн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн мэдээллийн дэлгэцээр “Инээмсэглэл Бидэнд Урам” гэсэн шторк, мэдээллийг тасралтгүй өдөрт 5 удаагийн давтамжтай, Файсбүүк групп дээр АТГ-аас гаргасан харандаан зурган шторк болон рекламыг тавьж 290 хүн шэйр хийн иргэдээс сэтгэлийн үг бичсэн байна.



2. БОЭТ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд иргэн төвтэй үйлчилгээг эрхэм болгох, иргэд эмч мэргэжилтний хоорондын эерэг дулаан үр дүнтэй харилцааг сайжруулах, ажиллагсдын харилцаа хандлага ёс зүйг сайжруулах зорилготой “Инээмсэглэл Бидэнд Урам” ажлын хүрээнд 13 ажлыг төлөвлөн 95 хувийг биелүүлэн



ажилласан.

БОЭТ-ийн Амбулатори, лаборатори, яаралтай тусламжийн үйлчилгээнд сувилагчдын оролцоог нэмэгдүүлэн үйлчлүүлэгчдийг угтаж тосох, чиглүүлэх, зөвлөх, үдэх үйлчилгээг шуурхай үзүүлэн иргэдэд инээмсэглэлээр угтах ажлыг зохион байгууллаа. Уг аянд 25 тасгийн сувилагчид төдийгүй эмч ажиллагсад хамрагдан үйл ажиллагааны 4 чиглэлийн хүрээнд иргэдэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

Төрөх тасгаас санаачлан зохион байгуулсан ажлын хүрээнд эх баригч нар хуваарийн дагуу 5 хоногийн туршид өглөөний 7.30 -11 цагуудад эмнэлгийн баруун талын төв хаалга, амбулаторийн 1.2.3-р давхар, клиник лаборатори, нөхөн сэргээх эмчилгээний тасаг, хүлээн авахын хэсгүүдэд үйлчлүүлэгчдийг инээмсэглэн угтан авч шаардлагатай кабинет, тасаг нэгжүүдийг зааж чиглүүлэх, тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллийг өгөх, үдэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаад иргэдийн зүгээс талархалтай хандан сэтгэл ханамжтай байлаа.

3. Жаргалант сумын эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд цахим мэдээллийг иргэдэд түгээж, угтах үйлчилгээг идэвхижүүлэн иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй түргэн шуурхай хүргэж ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар иргэдэд мэдээлэл өгч нийт 204 хүн шейр хийж, 611 хүн үзсэн байна. Мөн Хөтөчийн ширээ болон

эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн өрөөний хаалганд инээмсэглэл болон эерэг хандлагын талаар өглөө бүр шинэ **ишлэл** хэвлэн байршууллаа.

“Инээмсэглэл бидэнд урам” гэсэн үг нь үйлчлүүлэгч иргэд болон эмнэлгийн эмч, сувилагчид урам хайрласан сэтгэл санааг тогтвортой болоход нөлөөлсөн зэрэг эерэг байдлыг бий болгож байгаа нь ачаалал ихтэй ажилладаг ч нөлөөлөл үзүүлсэн ажил болсон. Нийт салбарын хэмжээнд 495 хүн шэйр хийж 901 хүн үзэж оролцсон байна.

 *Инээмсэглэл*
**БИДЭНД
УРАМ+**

“
Инээмсэглэл бол юутай ч зүйрлэшгүй сэтгэлийн их өглөг байдаг. Тийм ч учраас эмч хүн өвчтөнөө эдгээд инээмсэглэхэд л хамгийн их урам авдаг юм.

Эмч тандаа баярлалаа

**“МЭНДЦЭЦЭН”
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД:**

Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч
Болормаад баярласнаа илэрхийлье.

Оюут баг 9-39
тоотод оршин
суугч Бат-Очир

М.Цэвэлмаа
Хүний их эмч
Дэлхийн мисс 2019-д Монгол Улсаас оролцогч

 *Инээмсэглэл*
**БИДЭНД
УРАМ+**

“
Инээмсэглэл бол юутай ч зүйрлэшгүй сэтгэлийн их өглөг байдаг. Тийм ч учраас эмч хүн өвчтөнөө эдгээд инээмсэглэхэд л хамгийн их урам авдаг юм.

Эмч тандаа баярлалаа

**“МӨНХИЙН ГЭГЭЭ”
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД:**

Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төвийн эмч Мяндагханд, Ачит эмнэлгийн Цэнджав, Оюунгэрэл нар нь хүүхдийг минь эмчилж өгсөнд баярласнаа илэрхийлье.

Шанд баг 27-11
тоотод оршин суугч
Долгорсүрэн

М.Цэвэлмаа
Хүний их эмч
Дэлхийн мисс 2019-д Монгол Улсаас оролцогч



Уг аяны хүрээнд дараах ажлууд хийгдэж үр дүнгээ өгч ажиллалаа.

- БОЭТ-ийн Сувилахуйн албанаас “Эмнэлгийн ажилтаны инээмсэглэл, мэндчилгээ, эерэг бодол” сэдэвт сургалт болон Харилцааны дүрд тоглох сургалтанд нийт 150 эмч эмнэлгийн ажилтнууд хамрагдлаа.
- БОЭТ-ийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын ажлын хувцасыг жигдрүүлэн, нэг ижил загвартай, овог нэр, албан тушаал, тасаг нэгжийн нэр нь үйлчлүүлэгчид харагдахуйц энгэрийн тэмдэгтэй болсон.
- БОЭТ-ийн хэмжээнд тасгуудын эмч, сувилагч эмнэлгийн ажилтнууд хуваарийн дагуу өглөөний 7.30 -11.00 цагуудад эмнэлгийн баруун талын төв хаалга, амбулаторийн цаг товлох хэсэг, 1,2,3-р давхар, хүлээн авах яаралтай тусламжийн хэсгүүд, клиник лаборатори, дүрс онош, нөхөн сэргээх эмчилгээний тасгуудад үйлчлүүлэгчдийг инээмсэглэн угтан авч шаардлагатай кабинет, тасаг нэгжүүдийг зааж чиглүүлэх, дагуулах буюу тэргэнцэрээр хүргэж өгөх, тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллийг өгөх, сайн сайхныг хүсэн үдэх зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.
- Тайлант хугацаанд аймгийн иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах 70353511 утас, чанарын албанд ирүүлсэн талархалыг нэгтгэн дүгнээд “Иргэдээс хамгийн олон талархал хүлээсэн тасаг”-ийг анх удаа шалгаруулахад “Мэдрэлийн тасаг” шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.
- Орон нутгийн хэвлэл мэдээллээр хийж байгаа үйл ажиллагаа, иргэдээс ирсэн санал хүсэлийн дагуу шийдвэрлэж байгаа ажлуудыг 4 удаа мэдээллээ, Эрдэнэт зар facebook хаягаар “Инээмсэглэл Бидэнд Урам” аяны хүрээнд хийгдэж байгаа үйлчилгээг иргэд маш их талархан хүлээн авсанаа илэрхийлж байсан. Иргэдээс эмнэлгийн тусламж үйлчилгээ, ажиллагсдын харилцаа хандлага, ашиг сонирхлын талаар холбоотой гомдол санал ирээгүй бөгөөд аймгийн иргэдийн санал хүсэлт авах 70353511 утас, эмнэлгийн чанарын албанд бичгээр ируулсан талархал 10, өөрийн биеээр илэрхийлсэн талархал 1656 байлаа.